

АНУ, БНАСАУ-ын Удирдагч Нарын Магадлалт Уулзалт, Хэлэлцээрийн Нөхцөл Байдал ба Монгол Улсад Зохион Байгуулагдах Боломж

З.Мэнд¹

Ч.Анар²

Хураангуй: Солонгосын Хойг дахь нөхцөл байдал хурцдаж, АНУ, БНАСАУ хоорондын зөрчил цөмийн дайн өдөөж мэдэх түвшинд хүрч очсон эгзэгтэй үед хоёр орны удирдагчид яриа хэлэлцээр хийхээр урьдчилж тохироцсон нь дэлхийн хэмжээнд их хүлээлт, их эргэлзээг зэрэг бий болгов. Уг магадлалт хэлэлцээр чухам ямар өвөрмөц нөхцөл, түүхэн цаг үед явагдахыг Дэлхийн Аюулт Үзэгдлийн Эрсдлийн Хүрээлэнгээс гаргасан шинэлэг загварчлалд тулгуурлан шинжлэн судалж, улмаар уг хэлэлцээрийг Монгол Улсад зохион явуулах талаар манай улсын дэвшүүлсэн саналын хэрэгжих боломжийг үнэлж, тус хэлэлцээр зохиогдох газрын тухай таамгийг энэхүү өгүүллээр дэвшүүлнэ.

Түлхүүр үг: Зүүн Хойд Ази, Солонгосын Хойг, АНУ, БНАСАУ, Хоёр Солонгосын харилцаа, “Улаанбаатарын яриа хэлэлцээр” санаачилга, цөмийн дайн.

Abstract: *When the leaders of the USA and the DPRK agreed to hold a summit or dialogue in the midst of aggravated tension in Korean Peninsula, potentially signaling nuclear war; the international community started to experience great level of expectation and skepticism in regard thereto. This paper will cover an attempt to analyze peculiar circumstances and historic turning points under which the potential dialogue will be formulated with the help of nuclear war risk assessment model newly developed by the Global Catastrophic Risk Institute and further conduct assessment on the actuality of the offer made by the Mongolia to host such talks in its territory to eventually make predictions on the venue of the talks.*

Key words: *North East Asia, Korean Peninsula, the USA, the DPRK, Intra-Korean relations, “Ulaanbaatar Dialogue” Initiative, nuclear war.*

1. ШУА-ын Олон Улсын Харилцааны Хүрээлэнгийн ЭША (магистр).

2. Хархорум Хүрээлэн ТББ-ын судлаач, эрх зүйч (магистрант).

Өнөө цагт Солонгосын хойгийг тойрон үүсээд буй хурцадмал нөхцөл байдлыг өргөн хүрээнд авч үзвэл, Солонгосын ард түмний тусгаар тогтнолын төлөөх тэмцлээс гадна, 19-р зууны сүүл, 20-р зууны эхэн үед дэлхийд зонхилж байсан томоохон улс орнуудын улс төр, нийгэм, эдийн засаг, аюулгүй байдлын бодлого, ашиг сонирхлын ил, далд өрсөлдөөний гинжин урвалын үр дүн байх бөгөөд энэ хүрээнд сүүлийн жилүүдэд, тухайлбал 2017, 2018 онд олон улсын тавцанд тохиосон голлох үйл явдлын шалтгаант холбоо, мөн одоо өрнөж буй чухал үйл явдлын чиг хандлага бол чухамдаа зуун дамнан үргэлжлэн явагдаж байгаа түүхэн үр хөврөлийн эгзэгтэй үе шат, эргэлтийн цэгийг илтгэж байна.

БНСУ, БНАСАУ хоорондын нэгдлийн асуудал, БНАСАУ цөмийн зэвсэг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн явдал нь бүс нутгийн орнууд болон АНУ, ОХУ, БНХАУ, Япон Улс, дэлхийн бусад улс орнууд, НҮБ-ын анхаарлын төвд шилжиж, дэлхийн III дайны голомт Солонгосын хойгоос эхлэн асах вий гэх зүй ёсны болгоомжлолыг төрүүлээ.

БНАСАУ өөрийн тусгаар тогтнол, оршин тогтнох үндсэн бодлогыг АНУ-ын байнгын аюул заналхийллээс хамгаалах цөмийн зэвсэг эзэмших явдал хэмээн үзэж, түүнийгээ бодитоор хэрэгжүүлж эхэлсэн, үүнтэй зэрэгцэн АНУ өөрийн улсын төдийгүй, бүс нутаг, дэлхийн орнуудын аюулгүй байдалд заналхийлэл учруулж буй, цөмийн зэвсэг хөөцөлдсөн, “дайсагнасан” улс орон шинээр мэндэлж буйтай тулгарах болсон энэ үед, хоорондоо халз тулгарч, ил зөрчилдөх болсон энэ хоёр улс орны удирдагч нар, дипломат харилцаа тогтоогоогүй хэдий ч, хурцадмал асуудлыг шийдвэрлэхээр хоорондоо яриа хэлэлцээр хийх магадлал, хүлээлт бий болсон ба дэлхий дахинаа их хүлээлт, их эргэлзээг зэрэг төрүүлээд буй АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп, БНАСАУ-ын Удирдагч Ким Жон Ун нарын дээд хэмжээний уулзалт хэрэв бодитоор тохиох аваас чухал ач холбогдолтой, өвөрмөц онцлог үйл явдал болох нь гарцаагүй.

АНУ – БНАСАУ хоорондын яригдаж буй дээд хэмжээний уулзалтын газар орон, цаг, хэлэлцэх асуудал зэрэг нь хараахан эцэслэн шийдэгдээгүй, тодроогүй байх үед (2018 оны 03-р сарын 09-ний

өдөр) Монгол Улсын Ерөнхийлөгч асан Ц. Элбэгдорж тус түүхэн ач холбогдолтой дээд хэмжээний уулзалтыг Улаанбаатарт зохион байгуулахыг санал болгон, “Монгол Улс бол хамгийн тохиромжтой, төвийг сахисан газар нутаг. Бид тухайлбал, Япон, БНАСАУ хоорондын уулзалт зэрэг чухал яриа хэлэлцээрийг зохион байгуулж байсан”³ гээд, Зүүн Хойд Азийн аюулгүй, тогтвортой байдлын асуудлаарх “Улаанбаатарын яриа хэлэлцээр” санаачилгын туршлага, боломжид тулгуурлан уг арга хэмжээг зохион байгуулж болох тухай санааг дэвшүүлжээ. Үүний дараа (2018 оны 03-р сарын 16-ны өдөр) Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд АНУ-ын Элчин сайдын яамны түр хамаарагч М.Микаллер, БНАСАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд О Сын Хо-г нарын төлөөлөгчдийг тус тус хүлээн авч уулзан “Монгол Улс Зүүн Хойд Азийн энх тайван, тогтвортой байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн аливаа санал, санаачилгыг тууштай дэмжиж ирсэн бөгөөд БНАСАУ, БНСУ-ын хооронд дээд түвшний уулзалт хийхээр болсонд баяртай байгаагаа...мөн БНАСАУ болон АНУ-тай найрсаг харилцаатай цөөхөн орнуудын нэгийн хувьд тус улсуудын хооронд хийхээр яригдаж буй дээд түвшний уулзалтыг Монгол Улсад зохион байгуулах бүрэн боломжтой”⁴ гэдгээ илэрхийлжээ.

“Монгол Улс, Солонгосын хойг, цаашлаад Зүүн хойд Азийн энх тайван, аюулгүй байдалд хувь нэмэр оруулах гэсэн хүч чармайлтын илрэл”⁵ хэмээн БНАСАУ-ын талд үнэлэгдэж буй уг санал нь Монгол Улсын гадаад бодлогын үндсэн чиглэлд бүрэн нийцэхээс гадна, олон улсын хамтын нийгэмлэгт үзүүлэх нөлөө холбогдлыг нэмэгдүүлэх, бусад олон талын ач тус, үр дагавартай байж болох юм.

Энэхүү өгүүллээр АНУ – БНАСАУ хоорондын дээд хэмжээний уулзалт, яриа хэлэлцээр чухам ямар нөхцөл байдалд яригдаж буй зураглалыг тодорхойлж, тус яриа хэлэлцээр хийгдэх тохиолдолд уг арга хэмжээ Монгол Улсад зохион байгуулагдах боломж, магадлалд үнэлэлт өгөх оролдлого хийж таамаг, санал дэвшүүлэв.

3 Ц. Элбэгдорж твиттер хуудас, <https://twitter.com/elbegdorj/status/972065614238924800>


4 Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын цахим хуудсын мэдээ, <https://president.mn/?p=2696> , <https://president.mn/?p=2703>

5 Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын цахим хуудсын мэдээ, <https://president.mn/?p=2696>

ҮҮСЭЭД БУЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ЗУРАГЛАЛ:

АНУ, БНАСАУ-ын Удирдагч нарын уулзалт чухам ямар учраас өндөр ач холбогдолтой болохыг тодруулж, үүсээд буй нөхцөл байдлын зураглалыг гаргах үүднээс зөвхөн энэ онд өрнөсөн, холбогдол бүхий үйл явдлын өрнөл, чиг хандлагыг Дэлхийн Аюулт Үзэгдлийн Эрсдлийн Хүрээлэнгийн (Global Catastrophic Risk Institute) гаргасан цөмийн дайны магадлалыг тогтоох эрсдлийн загварчлалыг⁶ ашиглан үнэлж шинжлэн үзлээ. Энэхүү загварчлалын үйл явц, шатлалыг түүхэн өгөгдөл, мөн ирээдүйн болзошгүй зөрчлийн хувилбар нөхцөл байдлуудад үндэслэн үүсч болох дэс дараалсан үйл явдлын гинжин холбоог тооцож боловсруулсан. Уг загварчлал нь харилцан адилгүй хувилбар нөхцөл байдалд дэс дараалан бий болох үйл явдал бүрийн магадлалыг, улмаар нийт магадлалыг тооцоолох боломжийг олгох давуу талтай.⁷

Цөмийн дайнд хүргэх үйл явц, шатлалын зураглал (Mapping Pathways to Nuclear War):



6 2011 онд үүсгэн байгуулагдсан, эрсдлийн үнэлгээний хүрээлэн. <http://gerinstitute.org/about/>
 7 <https://globalchallenges.org/our-work/annual-report/new-models-of-nuclear-war-risk-assessment>

АНУ, БНАСАУ-ын хоорондын харилцаанд сүүлийн хоёр жилийн хугацаанд өрнөсөн үйл явдлын онцлог, чиг хандлагыг дээрх загварчлалын хүрээнд судлан үзэхэд, хоёр орны удирдагч нарын энэ оны 5-р сард хийхээр зэхэж буй гэх дээд хэмжээний уулзалт, яриа хэлэлцээр нь цөмийн дайнд хүргэж болзошгүй анхны цохилтыг хийхийн өмнөх үе болох “цөмийн дайралт хийгдээгүй үед аюул занал учирч байна гэсэн бодит ойлголт, итгэл” бий болсон шатлалд хамааруулж болох цаг үед товлогдсон байх ба энэ ч утгаараа зөвхөн оролцогч талуудын ашиг сонирхолд амин чухал нөлөөтэй төдийгүй, бүс нутаг, дэлхий дахинд нөлөө үзүүлэх, хариуцлагатай, эгзэгтэй, урьдчилан тааварлахад хүнд, түүхэн үйл явдал болохыг үгүйсгэхийн аргагүй юм (хавсралт хэсгээс энэ тухай цаг хугацааны хэлхээ, үйл явдлын тойм зураглалыг үзнэ үү). Түүхэн хөгжил, хөдөлгөөний энэ мэт өвөрмөц цаг үед тодорхой зөрчилд голлох үүрэг оролцоо бүхий хоёр орноор зогсохгүй, зөрчлийг тойрч эрх ашиг нь хөндөгдөж буй бусад улс орнууд ч гэсэн гэнэтийн алхам, шийдмэг зоримог өөрчлөлт, урьдчилан таамаглахад бэрх арга хэмжээг авч хэрэгжүүлдэг нь машид нийтлэг тул бид АНУ, БНАСАУ-ын удирдагч нарын уулзалтын өмнө зөвхөн эдгээр хоёр орны зүгээс төдийгүй, бусад улс орны зүгээс, тэр дундаа Зургаан талт хэлэлцээрийн оролцогч орнуудын талаас өөр өөрсдийн ашиг сонирхлыг бататган хангахад чиглэсэн гэнэтийн, таамаглахад бэрх, хурц цочмог алхам, арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь гарцаагүй юм.

ТУС ЯРИА ХЭЛЭЛЦЭЭР МОНГОЛ УЛСАД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ МАГАДЛАЛ

АНУ, БНАСАУ-ын удирдагчдын дээд хэмжээний магадлалт уулзалт, яриа хэлэлцээрийг Монгол Улсад зохион байгуулах боломжийг бодитоор үнэлж тогтооход маш олон хүчин зүйлсийг тооцох шаардлагатай. Тэдгээр хүчин зүйлсийг дараахь хэлбэрээр эрэмбэлэн ангилах нь зүйтэй гэж үзлээ. Тухайлбал:

Нэгдүгээрт, хэлэлцээрт оролцогч улс орны хэрэгцээ шаардлага, тусгай сонирхлыг;

Хоёрдугаарт, хэлэлцээрт оролцогч улс орны ойрын харилцаатай, холбоотон улсуудын хэрэгцээ шаардлага, тусгай сонирхлыг (тэр

дундаа, Зургаан талт хэлэлцээрийн оролцогч улс орнуудын);

Гуравдугаарт, хэлэлцээрт оролцогч болон бусад холбогдох улс орнууд харилцан зөвшөөрч сонгох (сонгогдож буй улс нь тус уулзалтыг зохион байгуулахад татгалзах зүйлгүй болохоо өөрөө илэрхийлсэн) улс байх шаардлагыг тус тус харгалзан үзвэл зохино.

Нэгдүгээр эрэмбийн хүчин зүйлийн дагуу, хэлэлцээрт оролцогч улс орны онцлог хэрэгцээ шаардлага, сонирхлыг хийсвэрлэн тооцвол: (цагаан толгойн үсгийн дарааллаар)

(1) АНУ:

- i. удирдагчийн аюулгүй байдлыг найдвартай хангах бололцоо, зорчин очих дөхөмтэй байдал;
- ii. уулзалт зохиогдох улстай харилцан хүндэтгэлтэй, найрсаг, дипломат харилцаа бүхий байх;
- iii. уулзалт зохиогдох улстай бодлогын түвшинд тулгамдсан өрсөлдөөн, зөрчилдөөнгүй байх;
- iv. уулзалт зохиогдох улс нь цөмийн зэвсэггүй улс байх;
- v. уулзалт зохиогдох улс төвийг сахих бодлоготой байх;
- vi. уулзалтын зохион байгуулалтад туслалцаа үзүүлэх зохих туршлага, зөөлөн дэд бүтэцтэй байх.

(2) БНАСАУ:

- vii. удирдагчийн аюулгүй байдлыг найдвартай хангах бололцоо, зорчин очих дөхөмтэй байдал;
- viii. уулзалт зохиогдох улстай харилцан хүндэтгэлтэй, найрсаг, дипломат харилцаа бүхий байх;
- ix. уулзалт зохиогдох улстай бодлогын түвшинд тулгамдсан өрсөлдөөн, зөрчилдөөнгүй байх;
- x. уулзалт зохиогдох улс нь БНАСАУ-тай адил цөмийн зэвсэг бүхий эсхүл цөмийн зэвсэг эзэмшиж байсан түүхэн туршлагатай улс байх;
- xi. уулзалт зохиогдох улс төвийг сахих бодлоготой байх;
- xii. уулзалтын зохион байгуулалтад туслалцаа үзүүлэх зохих туршлага, зөөлөн дэд бүтэцтэй байх.

Хоёрдугаар эрэмбийн хүчин зүйлийн дагуу, хэлэлцээрт оролцогч улс орны ойрын харилцаатай, холбоотон улсуудын өвөрмөц хэрэгцээ шаардлага, сонирхлыг хийсвэрлэн тооцвол: (цагаан толгойн үсгийн дарааллаар)

(3) БНХАУ:

- i. уулзалт зохиогдох улс төвийг сахих бодлоготой байх;
- ii. уулзалт зохиогдох улстай бодлогын түвшинд тулгамдсан өрсөлдөөн, зөрчилдөөнгүй байх;
- iii. Хоёр Солонгосын нэгдэл хэлэлцэх асуудлын хүрээнд яригдаж болзошгүй нь БНХАУ-ын хувьд хил, газар нутгийн маргаантай, эсхүл тийм төрлийн маргаан үүсч болох түүхэн улбаа шалтгаантай, түүнчлэн өөртөө засах эрхтэй харьяа улс, мужуудад үлгэрлэл үзүүлэх эрсдэлтэй тул хөрш зэргэлдээ орнуудад уулзалтыг зохион байгуулахаас татгалзах магадлал бий.

(4) БНСУ:

- i. АНУ, БНАСАУ-ын хэрэгцээ шаардлага, сонирхолд нийцсэн газар орон байх.

(5) ОХУ:

- i. уулзалт зохиогдох улс төвийг сахих бодлоготой байх;
- ii. уулзалт зохиогдох улстай бодлогын түвшинд тулгамдсан өрсөлдөөн, зөрчилдөөнгүй байх;
- iii. Хоёр Солонгосын нэгдэл хэлэлцэх асуудлын хүрээнд яригдаж болзошгүй нь ОХУ-ын хувьд хил, газар нутгийн маргаантай, эсхүл тийм төрлийн маргаан үүсч болох түүхэн улбаа шалтгаантай, түүнчлэн өөртөө засах эрхтэй харьяа улс, мужуудад үлгэрлэл үзүүлэх эрсдэлтэй тул хөрш зэргэлдээ орнуудад уулзалтыг зохион байгуулахаас татгалзах магадлал бий.

(6) Япон Улс:

- i. АНУ, БНАСАУ-ын хэрэгцээ шаардлага, сонирхолд нийцсэн газар орон байх.

Гуравдугаар эрэмбийн хүчин зүйлийн дагуу, хэлэлцээрт оролцогч

болон бусад холбогдох улс орнууд харилцан зөвшөөрч сонгох (сонгогдож буй улс нь тус уулзалтыг зохион байгуулахад таггалзах зүйлгүй болохоо өөрөө илэрхийлсэн) улс байх шаардлагыг хангаж чадах орныг тогтоохын тулд нэгдүгээр, хоёрдугаар, гуравдугаар эрэмбийн хүчин зүйлсийг нэгтгэн үзэж үнэлэлт хийх шаардлагатай болох юм.

Үүний тулд, юуны өмнө БНАСАУ-тай дипломат харилцаа бүхий улс орнуудын жагсаалттай танилцаж, тэдгээр улс орнууд дотроос АНУ, БНАСАУ-ын удирдагчдын дээд хэмжээний уулзалтыг зохион явуулах сонирхлоо илэрхийлсэн улс орныг авч үзэх хэрэгтэй. Нийтэд ил болсон мэдээллийн хүрээнд одоогоор Монгол Улс, Шведийн Вант Улс гэсэн хоёр улс ийм сонирхлоо албан ёсоор илэрхийлсэн ба зарим албан бус эх сурвалжийн мэдээнд үндэслэн ерөнхийлөн таамаглавал БНЭУ мөн уулзалтыг зохион байгуулж болох улс орон байхыг үгүйсгэхгүй тул эдгээр гурван улсыг сонгон үнэлэлт хийхийг оролдъё.

БНАСАУ-д Элчин сайдын яам бүхий 25 улс орон:

Бразил, Болгарь, Камбож, БНХАУ, Куба, Чех, Египет, Герман, Энэтхэг, Индонези, Иран, Лаос, Малайз, Монгол Улс, Нигерь, Пакистан, Палестин, Польш, Румын, ОХУ, Шведийн Вант Улс, Сири, Тайланд, Нэгдсэн Вант Улс, Вьетнам.



БНАСАУ-ын Элчин Сайдын яам байрлаж буй 51 улс орон:

Алжир, Египет, Экуадорын Гвиней, Этиоп, Гана, Гвиней, Ливи, Нигерь, Өмнөд Африк, Танзани, Уганда, Бразил, Куба, Мексик, Перу,

Венесуэл, Бангладеш, Камбож, БНХАУ, Энэтхэг, Индонези, Иран, Кувейт, Лаос, Малайз, Монгол Улс, Мьянмар, Балба, Пакистан, Сингапур, Сири, Тайланд, Вьетнам, Иемен, Австри, Беларус, Болгарь, Чех, Герман, Итали, Польш, Румын, ОХУ, Испани, Швед, Швейцар, Нэгдсэн Вант Улс.



АНУ, БНАСАУ-ын удирдагчдын дээд хэмжээний уулзалтыг Монгол Улс зохион байгуулах боломжийг харьцуулан үнэлэх нь:

Үзүүлэлт хүчин зүйл:	Монгол Улс	Шведийн Вант Улс	БНЭУ
удирдагчийн аюулгүй байдлыг найдвартай хангах бололцоо, зорчин очих дөхөмтэй байдал	Хангана	Хангана	Хангах боломжтой
уулзалт зохиогдох улстай харилцан хүндэтгэлтэй, найрсаг, дипломат харилцаа бүхий байх	Хангах боломжтой	Хангана	Хангана
уулзалт зохиогдох улстай бодлогын түвшинд тулгамдсан өрсөлдөөн, зөрчилдөөнгүй байх	Хангана	Хангана	Хангах боломжтой
уулзалт зохиогдох улс төвийг сахих бодлоготой байх	Хангах боломжтой	Хангана	Хангахгүй
Уулзалт зохиогдох улс нь цөмийн зэвсэггүй улс байх	Хангана	Ханган	Хангахгүй
уулзалт зохиогдох улс нь БНАСАУ-тай адил цөмийн зэвсэг бүхий, эсхүл цөмийн зэвсэг эзэмшиж байсан түүхэн туршлагатай улс байх	Хангахгүй	Хангана	Хангана

АНУ, БНАСАУ-ын удирдагч нарын магадлалт уулзалт

уулзалтын зохион байгуулалтад туслалцаа үзүүлэх зохих туршлага, зөөлөн дэд бүтэцтэй байх	Хангах боломжтой	Хангана	Хангана
Хоёр Солонгосын нэгдэл хэлэлцэх асуудлын хүрээнд яригдаж болзошгүй нь БНХАУ, ОХУ-ын хувьд хил, газар нутгийн маргаантай, эсхүл тийм төрлийн маргаан үүсч болох түүхэн улбаа шалтгаантай, түүнчлэн өөртөө засах эрхтэй харьяа улс, мужуудад үлгэрлэл үзүүлэх эрсдэлтэй тул хөрш зэргэлдээ орнуудад уулзалтыг зохион байгуулахаас татгалзах магадлал бий	Хангахгүй (Нийт 4 үзүүлэлт хангана гэж үзэх)	Хангана (Нийт 8 үзүүлэлт хангана гэж үзэх)	Хангана (Нийт 4 үзүүлэлт хангана гэж үзэх)

Монгол Улс, БНАСАУ дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ой энэ жил тохиож байна. Хоёр орон эдүгээ найрсаг харилцаатайгаас гадна, түүхийн өвөрмөц холбоо, нэгдмэл хувь заяа, адил төстэй шинж чанартай. Монгол Улсаас БНАСАУ-д олон удаа тусламж илгээж, Солонгосын дайны үед өнчирч үгүйрсэн хэдэн зуун хүүхдийг хүлээн авч байсан ба хоёр орон “социалист байгуулалтын үед нийтлэг нэгэн хувь заяагаар холбогдож байсны зэрэгцээ ... том гүрнүүдийн дунд бие дааж орших даацтай байх түүхэн шалгуур оногдсон”⁸ зэргээрээ, цаашилбал хоёул ОХУ, БНХАУ-тай хөрш залгаа оршдог, эдгээр улстай голлон худалдаа хийдэг, аль аль улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд бие даан хөгжих чадварын номлол бэхжин тусгагдсан, мөн гадаад улсын банкны салбар байгуулахыг зөвшөөрөөгүй үлдээд буй дэлхийн хоёрхон орон нь манай хоёр улс⁹ юм. Харин Монгол Улс, АНУ хоорондын харилцаа нь найрсаг, таатай буюу хоёр орон дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ойг 2017 онд тэмдэглэсэн бөгөөд АНУ бол Монгол Улсын хувьд улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын салбарт өргөн хүрээний хамтын ажиллагаатай, “гуравдагч хөрш” орон билээ.

Судлаачдын зүгээс харьцуулсан үнэлэлт өгөхдөө, Монгол Улсын хувьд (1) “харилцан хүндэтгэлтэй, найрсаг, дипломат харилцаа бүхий байх”, (2) “төвийг сахих бодлоготой байх”, (3) “уулзалтын зохион байгуулалтад туслалцаа үзүүлэх зохих туршлага, зөөлөн дэд бүтэцтэй байх” гэсэн шалгуур үзүүлэлтийг хангана гэлгүй, хангах боломжтой гэж үзсэний үндэслэл, шалтгаан:

8 Н. Сарантуяа, “Жүчэ гун ухаан ба бие даасан хөгжлийн онол, туршлага”, УБ., 2011 он, 99, 101-р хуудас.
9 Bloomberg TV Mongolia сувгийн мэдээлэл.

1) 2013 оны 04-р сарын 29-ний өдөр олон нийтэд зарласан Зүүн Хойд Азийн энх тайван, аюулгүй байдлын асуудлаарх “Улаанбаатарын яриа хэлэлцээр” санаачилга¹⁰ нь шинжлэх ухааны үндэслэлтэй, Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд бүрэн нийцсэн бүтээлч арга хэмжээ мөн боловч уг санаачилгыг зарласны дараахан буюу 2013 оны аравдугаар сарын 28-29-нд БНАСАУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэрээ Монгол Улсын Ерөнхийлөгч асан Ц. Элбэгдорж Ким Ир Сений нэрэмжит их сургуульд эрх чөлөө, хуулийг дээдлэх, хүний эрхийг хүндэтгэх тухай агуулгатай илтгэл тавьж, түүндээ “Ямар ч дарангуйлал мөнх бус... Эрх чөлөөтэй амьдрах гэсэн хүмүүсийн эрмэлзэл мөнх” гэж хэлээд, БНАСАУ-ыг Монголын замаар замнаж, шилжилтийн загварыг нь ашиглахыг зөвлөөд, тэгснээрээ ард түмэндээ эрх чөлөө олгохыг Пхеньянд дам уриалсан тухай мэдээлэл бий¹¹. Түүний илэрхийлсэн энэ байр суурь, зөвлөгөө бол түүний өөрийн санаачилж, үйл ажиллагааны хөтөлбөртөө тусгасан¹² “Улаанбаатарын яриа хэлэлцээр” санаачилгын үндсэн зарчим гэж тодорхойлогдсон “харилцан хүндэтгэлтэй хандах” шаардлагад үл нийцэх, үл нийцэхүйц гэж үнэлэгдэж болох алхам байсан хэмээн үзэж байна.

Энэ нь Монгол Улс БНАСАУ-ын талд Америк маягийн ардчиллыг “экспортлон” дамжуулах үзэл суртлын идэвхитэй арга хэрэгсэл ашиглаж байгаа мэт ойлголт төрүүлж, үүгээрээ уг Зүүн Хойд Ази дахь аюулгүй байдлын эгзэгтэй, олон талт асуудлаар Монгол Улс төвийг сахих бус, аль нэг талыг, тэр дундаа АНУ-ын талыг илт баримтлагч гэж ойлгогдох, АНУ-тай адил байр суурьтай байгаадаа үндэслэн БНАСАУ-д шахалт үзүүлэхийг хичээж буй улс хэмээн БНАСАУ-ын талд үнэлэгдэх эрсдэл дагуулсан гэж үзэх бүрэн үндэслэлтэй.

Мөн дээрхтэй ижил төстэй санааг Монгол Улсын Ерөнхийлөгч асан П. Очирбат 2016 онд БНСУ-ын Ариранг мэдээний агентлагт ярилцлага өгөхдөө дэвшүүлж, “Монгол Улс ардчилал, капитализмд шилжсэнээс хойшхи гуч шахам жилийн хугацаанд эдийн засгийн

10 Монгол Улсын Гадаад харилцааны яамны цахим хуудас дахь мэдээлэл, <http://www.mfa.gov.mn/wp-content/uploads/2015/12/Ulaanbaatar-Dialogue.pdf>

11 <http://www.sonin.mn/news/culture/30392>

12 Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 08-р сарын 29-ний өдрийн 142 дугаар зарлигийн хавсралт “Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр”, 5.6 дахь хэсэг; <http://www.legalinfo.mn/annex/details/6088?lawid=9588>

хувьд ихээхэн хөгжиж чадлаа. Энэ үйл явдал нь Пхеньянд ямар санааг дамжуулан илтгэж чадах вэ, мөн ямар санал зөвлөмжийг Пхеньяны эрх баригчдад таны зүгээс өгөхийг хүсч байна?” гэсэн сэтгүүлчийн асуултанд хариулахдаа, “эдийн засгийн өсөлт, эдийн засгийн хүчин чадлаар үндэснийхээ аюулгүй байдал, ард иргэдийнхээ аюулгүй байдлыг хамгаалах ийм шинэ нөхцөл байдал бий болоод байгаа юм... Монголоос авмаар аятайхан боломжийн юм [туршлага] байвал одоо аваад, тэгээд хөгжье гэж би Хойд Солонгосынхондоо уриалмаар байна”¹³ гэж ярьсан.

БНАСАУ-аас Монгол Улсад сууж байсан Элчид сайд Жөн Жан Ён 1996 оны 06-р сарын 07-ны өдөр Монгол Улсын Гадаад харилцааны яамны УТГ-ын орлогч дарга Л. Даваагивт БНАСАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамаа хаах болсноо мэдэгдэж, дараа өдөр нь уулзахдаа, “Өмнөд Солонгосын эрх баригчдын харгис хуурмаг “нарны элч” бодлого нь манай ард түмийг доромжилсон хэрэг юм. Энэ нь АНУ-аас хуучин ЗХУ-ыг задалж, “энх тайвнаас өөрчилнө” гэсэн харгис бодлогын Өмнөд Солонгос маягийн хувилбар юм. Тайванийг ашиглаж БНХАУ-ыг “энх тайвнаар өөрчлөх” бодлогын адил хувилбар ... Монголын Засгийн газар нэгдлийн эсрэг чиглэсэн энэхүү бодлогыг дэмжиж, түүнд амжилт гаргахыг хүсч, хамтран ажиллахаа амласан нь Умард, Өрнөдийн харилцаанд төвийг сахина гэсэн байр сууринаасаа ухарч, Өмнөд Солонгосын бодлогыг дэмжигч болж хувирсныг харуулж байна. Энэ нь дайснуудтай сөрөн зогсч байгаа манай Засгийн газрын урмыг хугаллаа. Монголд суугаа Элчин сайдын яамыг хаахыг шаардаж байна”¹⁴ хэмээн мэдэгдэж байсан түүхэн баримт бий. Уг Элчин сайдын яамыг хаасан, эргүүлэн нээсэн асуудал нь үнэн хэрэгтээ санхүү, эдийн засгийн шалтгаантай гэсэн байр суурь байдаг хэдий ч, БНАСАУ-ын цөмийн хөтөлбөртэй холбоотой асуудалд Монгол АНУ ба барууны орнуудын байр суурьтай нэгдсэнийг БНАСАУ-ын тал таагүй хүлээн авсан¹⁵ бодит нөхцөл байдал бий тул, Монгол Улс уг асуудлаар төвийг сахисан байр суурьтай гэсэн аливаа төрлийн албан бус тунхаглал нь

13 “Mongolia's First President speaks on N. Korean approach”, July 20, 2016. <https://www.youtube.com/watch?v=bWS65pkmkYo>

14 Монгол Улсын Гадаад харилцааны яамны архив. Хн: 211,

15 С. Батсайхан, “1990-ээд оны Монгол Улс, БНАСАУ-ын харилцаа: БНАСАУ Монгол дахь ЭСЯ-аа хаасан нь хоёр орны гадаад бодлогын онцлог”, Олон улсын харилцаа сэтгүүлийн 2016 оны №1/32 (458) дугаар, 21-р хуудас.

ямартаа ч БНАСАУ-ын талд хүлээн зөвшөөрөгдөх төлөвгүй бөгөөд ийм төрлийн тунхаглал нь одоогийн нөхцөлд өөрөө өөртөө өгсөн үнэлэлт төдий байна.

2) Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын хууль тогтоомжид “төвийг сахих бодлого” хэрэгжүүлэх, мөн “Улаанбаатарын яриа хэлэлцээр” санаачилгын эрх зүйн байдлыг бүрэн тодорхойлж өгсөн зохицуулалт хараахан тусгагдаагүй байна.

Төвийг сахих бодлого хэдий хуульчлан баталгаажаагүй байлаа ч, тухайн орны төрийн бодлого, үйл ажиллагаа, иргэний нийгэм, олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн амьдралын хүрээнд тодорхойлогдон оршиж байвал мөн чухал нөлөөтэй байх юм. Тухайлбал, Английн BBC агентлагийн 2014 онд явуулсан судалгаагаар нийт Энэтхэгчүүдийн дөрөвний нэгтэй тэнцэх хувь нь БНАСАУ дэлхий дахинд эерэг нөлөөг үзүүлж байна хэмээн үздэгийг тогтоосон байна¹⁶.

Монгол Улсад БНАСАУ-ын талаарх мэдээ, мэдээлэл тэнцвэргүй хэлбэрээр тараагддаг бөгөөд БНАСАУ-ын Солонгосын мэдээний төв агентлагаас эх сурвалжаа албан ёсоор авч нэвтрүүлдэг хэвлэл мэдээллийн хэрэгсэл судлаачдын мэдэгдхүүний хүрээнд одоогоор байхгүй байна. Манай улсын иргэд, олон нийт БНАСАУ-ын талаар тэнцвэртэй мэдээллээр хангагддаггүй тул бүрэн гүйцэт, бодит ойлголт, төсөөлөлгүй гэж үзэх үндэслэлтэй. Зөвхөн олон нийт төдийгүй, төрийн өндөр дээд албан тушаал хашиж байсан хүмүүс БНАСАУ-ын талаар төвийг үл сахисан, хурц ширүүн мэдэгдэл, яриа таниулга хийдгийн жишээ гэвэл, Нийслэл хотын Засаг дарга асан Э. Бат-Үүлийн БНАСАУ-ыг хурц шүүмжлэн элэглэсэн нийтлэл¹⁷, бичвэр¹⁸, Тагнуулын ерөнхий газрын дарга асан Б. Хурц БНАСАУ-ын төлөөлөгч нарын дохио зангаа хэрэглэн ярьсныг “цаазаар авахуулсан” гэж өөрөө ойлгосны үндсэн дээр нийгмийг цочроосон мэдэгдэл¹⁹ хийсэн, 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр нэр дэвшигч М. Энхболдын

16 “World War 3 fears as INDIA wades into North Korea row - relations at breaking point”, October 29, 2017, <https://www.express.co.uk/news/world/872087/north-korea-usa-india-relations-world-war-3>

17 “Э.Бат-Үүл: Ерөнхийлөгч Баттулга, цэргийн социализмаа яаж байгуулах юм бол?!” , 2018 оны 01-р сарын 17-ны өдөр, <http://www.zaluu.mn/p/41262.html>

18 Э. Бат-Үүл твиттер хуудас, https://twitter.com/e_batuul/status/850366404188446721?lang=bg

19 Б. Хурцын ярилцлага, “Цэнзургүй яриа” нэвтрүүлэг, 2017 оы 11-р сарын 20-ны өдөр, <https://www.youtube.com/watch?v=XqxTNFh0YGE>

сурталчилгаанд БНАСАУ-ыг иш татан ардчилсан нэртэй ч ардчилсан орон бус гэх зэргээр ярьж байсан тохиолдлууд юм.

3) Дэлхийн Банкнаас эрхлэн гаргасан “2017-2018 оны Дэлхийн орнуудын өрсөлдөх чадварын тайлан” судалгаанд Монгол Улс 101-р байранд, Шведийн Вант Улс 7-р байранд, БНЭУ 40-р байранд тус тус жагсжээ²⁰. Бид Зүүн Хойд Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн бодлогыг дэмжих оролцоходоо өөрийн улсын мэргэшсэн боловсон хүчний чадавхийг тогтмол дээшлүүлэх чиглэлд тууштай анхаарч ажиллах шаардлага бий хэмээн үзэж байна.

ДҮГНЭЛТ:

Дээрх үнэлэлтэд үндэслэн таамаг дэвшүүлбэл, АНУ, БНАСАУ-ын удирдагчдын дээд хэмжээний уулзалт, яриа хэлэлцээр бодитоор зохиогдох тохиолдолд, Шведийн Вант улсын нутаг дэвсгэрт явагдах магадлалтай бөгөөд Монгол Улсад зохиогдох магадлал нь Шведийн Вант улсад зохиогдох магадлалтай харьцуулахад илт бага байна. БНЭУ-ын хувьд одоогоор тус яриа хэлэлцээрийг зохион байгуулах сонирхлоо албан ёсоор илэрхийлээгүй тул таамаг дэвшүүлэхэд зохимжгүй байна. Товчхондоо, Монгол Улсын хувьд төвийг сахих бодлого нийгмийн амьдралын хүрээнд зохих түвшинд тусгагдаж чадаагүйгээс гадна, манай улсын зүгээс өөрийн санал болгож буй яриа хэлэлцээрийн санаачилгынхаа үнэт зүйлс, зарчмуудыг бодитоор хэрэгжүүлж чадах эсэхэд үндэслэл бүхий эргэлзээ үүссэн байна гэж үзлээ.

Солонгосын хойгт үүссэн хурцадмал байдал бол цөмийн дайнд хүргэж болзошгүй, онцгой хүнд цаг үе мөн тул, уг асуудалтай холбоотой яриа хэлэлцээрийг зохион явуулахад зөвхөн үндсэн оролцогч нарын талаас төдийгүй, зуучлагч, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэгч аль нэг улс орны талаас ч тэр онцгой анхаарал, өндөр бэлтгэл, чадавхи шаардах нь гарцаагүй байна. Иймд Монгол Улсын хувьд яриа хэлэлцээрийн санаачилгаа төгөлдөржүүлэх, бэлтгэл, чадавхи нэмэгдүүлж сайжруулах чиглэлд бодлогын түвшинд тууштай анхаарч ажиллах нь ач холбогдолтой юм. Зүүн Хойд Ази, Солонгосын хойгт үүсээд буй тулгамдсан асуудлыг энх тайванч, дипломат аргаар

20 <https://www.weforum.org/reports/the-global-competitiveness-report-2017-2018>

шийдвэрлэхэд Монгол Улс хувь нэмрээ оруулах боломж бололцоо өргөн дэлгэр байх бөгөөд гадаад бодлогын энэхүү томоохон нөөц бололцоог манай улс бүрэн дүүрэн ашиглахын тулд нэн тэргүүнд өөрсдөөс шалтгаалах, дотоод хүчин зүйлээ бүтээлчээр шийдвэрлэх шаардлагатай байна.

Энэхүү өгүүлэлд тусгагдсан агуулга, санаа бол гагцхүү судлаачид тухайн цагт олж цуглуулсан мэдээ баримтдаа тулгуурлан бэлтгэсэн бие даасан үнэлэлт ба аль нэг байгууллага, хувь хүний тогтсон байр суурь, үзэл бодлыг илэрхийлэхгүй.

Хавсралт: Үйл явдлын өрнөл, нөхцөл байдлын зураглал:

“2017 оны 01-р сарын 03-ны өдөр: БНАСАУ-ын удирдагч Ким Жон Ун тус улс тив алгасагч баллистик пуужинг үйлдвэрлэж дуусах шатанд орсныг шинэ жилийн өдөр мэдэгдсэний хариуд АНУ-ын ерөнхийлөгч Доналд Трамп өөрийн твиттер хуудсанд “... Энэ төлөвлөгөө нь бүтэхгүй!” хэмээн мэдэгдэв.

2017 оны 01-р сарын 19-ний өдөр: Ерөнхийлөгч Доналд Трамп өөрийн албан үүргийг хүлээн авч тангараг өргөхөөс нэг өдрийн өмнө, Пхеньяны баруун өмнөд хэсэгт байрлах “Чамжин” нэртэй пуужингийн үйлдвэрт идэвхижил илэрснийг АНУ-ын тандалтын хиймэл дагуулууд тогтоож, тус улс хоёр ширхэг тив алгасагч баллистик пуужинг туршихаар бэлтгэж буй дохиог дуулгав.

2017 оны 02-р сарын 11-ний өдөр: Доналд Трамп ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа эхэлснээс хойшхи анхны баллистик пуужинг Пхеньян (“CNN” агентлагийн мэдээллэснээр) Ким Жон Ун удирдагчийн биечлэн өгсөн тушаалын дагуу харвав. БНАСАУ-ын удирдагч тус пуужин хөөргөх ажиллагаанд биечлэн оролцсон гэсэн мэдээ бий. Доналд Трамп ерөнхийлөгч уг пуужин харвасан асуудлаар Япон Улсын ерөнхий сайд Шинзо Абэтэй гольфийн сургуулилт хийх үеэрээ оройн зоог барьж санал солилцов.

2017 оны 02-р сарын 14-ний өдөр: Ким Жон Уны эцэг нэгтэй ах Ким Жон Намыг Малайз Улсын Куала Лумпур олон улсын нисэх буудлаар зорчих үед нь хордуулж амь хөнөөв.

2017 оны 03-р сарын 06-ний өдөр: БНАСАУ Япон тэнгисийн

чиглэлд дөрвөн пуужин харваж бүс нутаг дахь АНУ-ын холбоотон улсыг заналхийлэв. Тав дахь баллистик пуужин нь хөөрч чадаагүй байна.

2017 оны 03-р сарын 14-ний өдөр: Хэд хоногийн өмнө пуужин буусан цэгүүдэд АНУ, Япон Улс, БНСУ тус тус өндөр технологийн пуужин хамгаалах хөлөг онгоцууд илгээв. Пхеньян энэ сарын сүүлээр пуужингийн хөдөлгүүр, пуужин турших зэргээр хариу үзүүлэв.

2017 оны 04-р сарын 06-ны өдөр: Доналд Трамп ерөнхийлөгч БНХАУ-ын дарга Ши Жиньпинтэй албан уулзалт хийхээс цөөн хоногийн өмнө БНАСАУ Солонгосын хойгоос дахин нэг пуужинг галлав. Доналд Трамп ерөнхийлөгч уг цэргийн хүчин чадал харуулсан үйлдэлд хариу өгч Ши Жиньпин даргатай уулзах үеэрээ Сири Улсад пуужингаар цохилт өгөхийг тушаав.

2017 оны 04-р сарын 09-ний өдөр: АНУ-ын усан цэргийн Карл Винсон цохилтын бүлэг тогтсон хуваарийн дагуу Австрали улсад хүрэлгүйгээр Номхон далайн баруун хэсгийг шууд зорих тухай мэдэгдэв. Цагаан ордны зүгээс үүнийг БНАСАУ-ын өдөөн хатгалгыг няцаах зорилготой арга хэмжээ хэмээн тайлбарлав. Хэдий ийнхүү мэдэгдэл гарсан ч, тус цохилтын бүлэг Солонгосын хойгийг зүглээгүй бөгөөд Энэтхэгийн далайд хамтарсан сургуулилт хийхээр Австралийн усан цэрэгтэй нийлсэн тухай мэдээ ирсэн. Энэ тухай Цагаан ордны тухайн үеийн хэвлэлийн төлөөлөгч мэдээлэл өгөхдөө тус цохилтын бүлэг нь яваандаа Япон тэнгисийг зорин хүрэх болно гэв.

2017 оны 04-р сарын 14-ний өдөр: АНУ өөрийн орны цэрэг зэвсгийн чадал хүчийг харуулахаар Лалын Улс (ISIS)-ыг онилж хамгийн хүчтэй цөмийн бус бөмбөгийг Афганистан Улсад хаяв. Түүний дараахан Ким Жон Ун удирдагч Пхеньянд жил тутам зохиодог цэргийн жагсаалдаа шинэ пуужин, зэр зэвсгээ гарган харуулж өөрийн орны цэргийн хүчин чадлыг илтгэв.

2017 оны 04-р сарын 20-ны өдөр: НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл Пхеньян пуужин харвасныг албан ёсоор буруутгаж, ийм түрэмгий үйл ажиллагаагаа “нэн даруй” зогсоохыг шаардав.

2017 оны 04-р сарын 29-ний өдөр: АНУ-ын усан цэргийн Карл Винсон цохилтын бүлэг Японы тэнгист хүрч очив.

2017 оны 05-р сарын 01-ний өдөр: Доналд Трамп ерөнхийлөгч телевизийн ярилцлагад (CBS: Face the Nation) орох үеэрээ БНАСАУ-ын харвасан пуунжингуудыг жижиг пуужин байсан хэмээн үнэлж, Ким Жон Ун удирдагчийг “ухаалаг хүн” хэмээн үнэлж байгаагаа илэрхийлэв. Мөн өөр нэгэн ярилцлагадаа, Доналд Трамп ерөнхийлөгч Ким Жон Ун удирдагчтай “нөхцөл байдал зөв бүрэлдсэн үед” уулзах нь “нэр хүндийн хэрэг” байх болно хэмээн яриу.

2017 оны 05-р сарын 14-ний өдөр: БНСУ-ын шинэ ерөнхийлөгч Мүүн Жае Ин албан үүргээ хүлээн авснаас хойшхи анхны пуужинг БНАСАУ харвав.

2017 оны 06-р сарын 02-ны өдөр: БНАСАУ мөн оны 5-р сард туршилтаар пуужин харвасантай холбогдуулан цөмийн ба пуужингийн хөтөлбөрүүдэд чиглэсэн нэмэлт хориг арга хэмжээг авахаар НҮБ санал нэгтгэй шийдвэрлэв.²¹

2017 оны 06-р сарын 08-ны өдөр: Нэмэлт хориг авсан нь төдийлөн үр дүнд хүрээгүй ба хориг арга хэмжээ авснаас цөөн хоногийн дараа Пхеньян Солонгосын хойгийн далайд хөлөг онгоц эсэргүүцэх дөрвөн пуужинг галлав.

2017 оны 07-р сарын 04-ний өдөр: АНУ Тусгаар тогтнолын өдрөө тэмдэглэж байх үед БНАСАУ “дэлхийн аль ч цэгт хүрэх” чадвартай тив алгасагч баллистик пуужингийн анхны туршилтаа амжилттай явуулав.

2017 оны 07-р сарын 08-ны өдөр: ХБНГУ-ын Хамбург хотноо зохиогдсон Их-20 уулзалтын үеэр Доналд Трамп ерөнхийлөгч БНАСАУ-ын дарга Ши Жиньпинд БНАСАУ-ын цөмийн зэвсгийн хөтөлбөрийг зогсооход Хятадын зүгээс хүчин чармайлтаа нэмэгдүүлэхийг шаардав.

2017 оны 07-р сарын 28-ны өдөр: Пхеньян дахин пуужин хөөргөж 7-р сард хоёр дахь удаагаа туршилт хийв. БНСУ-ын зэвсэгт хүчний өндөр дээд албан тушаалтнуудын хэлснээр энэ удаагийн туршилт нь 07-р сарын 04-ний өдрийнхтэй харьцуулахад илүү дэвшилтэт боловсронгуй аргаар явагдсан ба зарим шинжээчид тэрхүү пуужин нь АНУ-д цохилт өгөх чадавхитай байж болзошгүйг анхааруулав.

2017 оны 08-р сарын 05-ны өдөр: БНАСАУ цөмийн пуужингийн

21 НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн №2356 (2017) шийдвэрийг бүрэн эхээр үзэх холбоос: [http://undocs.org/S/RES/2356\(2017\)](http://undocs.org/S/RES/2356(2017))

туршилт удаа дараалан явуулж, цөмийн зэвсэг бүтээхээр тасралтгүй чармайн ажиллаж буйг харгалзан НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл тус улсад шинэ хориг арга хэмжээ авахаар санал нэгтгэж шийдвэр гаргав.²² Доналд Трамп ерөнхийлөгч өөрийн твиттер хуудсанд “НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл Хойд Солонгост хориг арга хэмжээ авахаар 15-0 саналаар шийдвэрлэв. Хятад, Орос улсууд бидэнтэй санал нэг байлаа. Маш том санхүүгийн нөлөө үзүүлнэ!” гэж бичив.

2017 оны 08-р сарын 07-ны өдөр: НҮБ-ын санал хураалт явагдсанаас хоёр өдрийн дараа, БНАСАУ-ын зүгээс хэрэв АНУ цэрэг зэвсэг хөдөлгөн халдан довтолбол түүний эсрэг цөмийн зэвсэг ашиглахаа мэдэгдэв.²³

2017 оны 08-р сарын 08-ны өдөр: БНАСАУ баллистик пуужинд цөмийн цэнэгтэй хошуу овор хэмжээг нь жижигрүүлэн байршуулах ажлыг амжилттай гүйцэтгэсэн тухай судалгааг мэдээллэв.²⁴ Цөмийн зэвсгийн талаарх мэдээ хоёр орон бие биенээ заналхийлэхэд хүргэж таагүй харилцааг улам хурцатгах болов. Хэрэв Пхеньян АНУ-ын эсрэг заналхийллээ үргэлжлүүлбэл “гал, хилэн” ноцоон турхирна хэмээн Доналд Трамп ерөнхийлөгч хэлэв. Ийнхүү хэлснээс нь хойш, хэдэн цагийн дараа БНАСАУ-ын төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр Солонгосын Ардын Армийн хэвлэлийн төлөөлөгч тус улс Номхон далайд байрладаг, АНУ-ын харьяаны Гуам аралд пуужингаар цохилт өгч болох төлөвлөгөөг нухацтай хэлэлцэж байгаа тухай төрийн мэдэгдэв.²⁵

2017 оны 08-р сарын 28-ны өдөр: БНАСАУ Япон Улсын дээгүүр пуужин харвав. Энэ сард БНАСАУ-ын гадаад худалдааны 90% гаруй хувийн эргэлтийг хангадаг БНХАУ тус улсаас нүүрс, төмөр, төмрийн

22 НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн №2371 (2017) шийдвэрийг бүрэн эхээр үзэх холбоос: [http://undocs.org/S/RES/2371\(2017\)](http://undocs.org/S/RES/2371(2017))

23 Ben Otto, Jake Maxwell Watts, Farnaz Fassihi, “North Korea says it would use nukes only against U.S.”, August 07, 2017, https://www.wsj.com/articles/no-north-korea-talks-while-missiles-are-flying-tillerson-says-1502084784?mod=fox_australian&btz4=1908081807

24 Joby Warrick, Ellen Nakashima and Anna Fifield, “North Korea now making missile-ready nuclear weapons, U.S. analysts say”, August 08, 2017, https://www.washingtonpost.com/world/national-security/north-korea-now-making-missile-ready-nuclear-weapons-us-analysts-say/2017/08/08/e14b882a-7b6b-11e7-9d08-b79f191668ed_story.html?utm_term=.13dc73988ff6

25 “North Korea seriously considering strike on Guam, state media outlet says”, August 09, 2017, <https://www.cnn.com/2017/08/08/north-korea-seriously-considering-strike-on-guam-reports-citing-state-media.html>

хүдэр, далайн хүнс зэргийг импортлон авахаа зогсоох шийдвэр гаргаж, НҮБ-ын хоригийг хэрэгжүүлж ажиллахаар болсон²⁶.

2017 оны 09-р сарын 03-ны өдөр: БНАСАУ тив алгасагч баллистик пуужинд суурилуулах боломжтой овор хэмжээг нь жижигрүүлсэн устөрөгчийн бөмбөг амжилттай туршсан болохоо мэдэгдэв. АНУ-ын Батлан хамгаалахын сайд Жэймс Маттис БНАСАУ хэрэв АНУ буюу түүний холбоотныг заналхийлэхгүй байхыг сануулж, эс бөгөөс цэргийн хариу цохилт өгөх болохыг анхааруулав.²⁷

2017 оны 09-р сарын 19-ний өдөр: НҮБ-ын Ерөнхий Ассемблейн хуралд АНУ-ын ерөнхийлөгч Доналд Трамп үг хэлэхдээ, “АНУ-д чадал, тэвчээр их бий ч гэлээ хэрэв өөрийгөө буюу өөрийн холбоотон улсыг хамгаалахаар өөр аргагүйд хүрвэл бид Хойд Солонгосыг бүрмөсөн устгахаас өөр сонголтгүй. Пуужингийн Эзэн өөрийнхөө, мөн дэглэмийнхээ хувьд амиа егүүтгэх даалгавар гүйцэтгэж байгаа гэсэн үг. АНУ үүнийг хийхэд бэлэн, дуртайяа чадах хэдий ч ийм шаардлага гарахгүй хэмээн найднам. Энэ бол НҮБ-ын гол зорилго, энэ бол НҮБ-ын оршин байгаа шалтгаан юм. Тэгэхлээр хэрхэхийг нь харцгаая. Цөмийг зэвсэггүй болох нь БНАСАУ-ын цорын ганц хүлээн зөвшөөрөгдөх ирээдүй болохыг ухаарах цаг ирсэн...Бид улам их хичээх хэрэгтэй. Кимийн дэглэм дайсагнасан зан байдлаа зогсоох хүртэл түүнийг тусгаарлан шахахын тулд улс болгон чармайн ажиллах цаг болжээ”²⁸ гэв.

2018 оны 01-р сарын 01-ний өдөр: “БНАСАУ 2018 оны Өвлийн Олимпын наадамд оролцож магадгүй тухай Ким Жон Ун Удирдагч шинэ жилээр яриу. Мөн хэрэв БНАСАУ-ыг заналхийлбэл “цөмийн зэвсэг ашиглах товчлуур” ширээн дээр нь бэлхэн буйг АНУ-д сануулаад, гэхдээ БНСУ-тай “яриа хэлэлцээр хийхэд нээлттэй” байгаа бөгөөд БНАСАУ нь “энх тайванч, цөмийн зэвсгийг хариуцлагатай эзэмшигч” орон юм хэмээн зарлав.²⁹ Энэ үйл явдлын дагуу 2018 оны 01-р сарын

26 “China imposes import bans on North Korean iron, coal and seafood”, August 15, 2017, <http://www.bbc.com/news/business-40932427>

27 Julia Manchester, Olivia Beavers, “Trump and North Korea: A timeline on escalating tensions”, September 03, 2017, <http://thehill.com/homenews/administration/349088-timeline-trumps-relationship-with-north-korea>

28 “President Trump's speech to the UN General Assembly” <https://edition.cnn.com/2017/09/19/politics/president-trump-united-nations-speech/index.html>

29 “North Korea's Kim 'open to dialogue' with South Korea, will only use nukes if threatened”, January 01,

03-ны өдөр Сөүл – Пхеньян хоорондын харилцах зурвасыг сэргээн нээж, мөн сарын 20-ны өдөр БНАСАУ өвлийн олимпод 22 тамирчин оролцуулах болсныг баталгаажуулж мэдэгдэв.³⁰ АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп өөрийн твиттер хуудсанд 01-р сарын 03-ны өдөр “Хойд Солонгосын Удирдагч Ким Жон Ун “цөмийн зэвсэг ашиглах товчлуур ширээн дээр нь байнга бэлэн байдгийг” саяхан мэдэгдсэн. Надад ч мөн адил “цөмийн зэвсэг ашиглах товчлуур” байгаа гэдгийг, харин минийх түүнийхээс хавьгүй том бөгөөд хүчтэй зэвсэг болохыг, бас ажилладаг товчлуур гэдгийг нөөц нь шавхагдаж, хүнсний хомсдолд орсон дэглэмийнх нь хэн нэгэн хүн түүнд хэлээд өгөөч!” гэж бичив.

2018 оны 02-р сарын 08-ны өдөр: Өвлийн Олимпийн наадмын өмнөх өдөр буюу БНАСАУ-ын зэвсэгт хүчин үүсгэн байгуулагдсаны 70 жилийн ойг тохиолдуулан зохиогдсон цэргийн жагсаалын үеэр тус улсын Удирдагч Ким Жон Ун илтгэлдээ “...Дэлхийд империализм оршин тогтнож, АНУ Хойд Солонгосын эсрэг дайсагнасан бодлого хэрэгжүүлсээр байгаа цагт Солонгосын Ардын Армийн зорилго бол улс орон, ард түмнээ бат хамгаалах хүчирхэг илдийн үүрэг гүйцэтгэх явдал бөгөөд ингэж чадвал энх тайван үл алдагдана”³¹ гэж яриу.

2018 оны 02-р сарын 09-ний өдөр: БНАСАУ, БНСУ-ын тамирчид 2018 оны Өвлийн Олимпийн наадмын нээлтэнд Солонгосын нэгдлийн туг дор жагсаж, нээлтийн арга хэмжээнд Ким Жон Ун Удирдагчийн охин дүү Ким Ё Жон, мөн тус улсын Ард түмний дээд зөвлөлийн Ерөнхийлөгч Ким Ёнг Нам нар биечлэн оролцов. Энэ үеэр НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутеррес БНАСАУ-ын Ард түмний дээд зөвлөлийн Ерөнхийлөгч Ким Ёнг Намтай уулзаж, талууд энх тайванч аргаар цөмийн зэвсэггүй болох үүднээс яриа хэлэлцээрийг сонгоно хэмээн найдаж байгаагаа уламжилсан³².

2018 оны 02-р сарын 10-ны өдөр: БНАСАУ-ын төлөөлөгч нар,

2018, <https://www.reuters.com/article/us-northkorea-missiles-kimjongun/north-koreas-kim-open-to-dialogue-with-south-korea-will-only-use-nukes-if-threatened-idUSKBN1EQ0NJ>

30 “N. Korea to send 22 athletes in three sports to PyeongChang Winter Olympics”, January 20, 2018, <http://english.yonhapnews.co.kr/news/2018/01/20/0200000000AEN20180120003653315.html>

31 “A Message to Washington’: The Rationale Behind N Korea’s Military Parade”, February 09, 2018, <https://sputniknews.com/analysis/201802091061497667-north-korea-military-parade-message-us-olympics/>

32 “UN Chief Meets North Korean President at Olympics, Stresses Need for Dialogue”, February 09, 2018, <https://sputniknews.com/asia/201802091061526394-guterres-speaks-kim-jong-nam/>

тухайлбал Ким Жон Ун Удирдагчийн охин дүү Ким Ё Жон БНСУ-ын Ерөнхийлөгч Мүүн Жае Интэй уулзах үеэрээ хоёр-Солонгосын гурав дахь удаагийн дээд хэмжээний уулзалтыг Пхеньянд хийх урилгыг дамжуулж, БНСУ-ын Ерөнхийлөгч урилгыг хүлээн авсан байна. БНСУ-ын Ерөнхийлөгч “Өмнөд ба Хойд Солонгос хоорондын харилцааг сайжруулахад АНУ болон Хойд Солонгос хоорондын яриа хэлэлцээрийг эртхэн эхлүүлж өрнүүлэх шаардлагатай” хэмээн ярьсан байна.³³

2018 оны 02-р сарын 13-ны өдөр: Япон Улсын Батлан хамгаалахын сайд Ицунори Онодера “Хэрэв Хойд Солонгос энэхүү [Олимпийн наадмын] арга хэмжээг улс төрийн зорилгоор ашиглах гэж оролдон олон улсын хамтын нийгэмлэгийн шахалтыг зөөлрүүлэх гэвэл энэ мэхэнд нь бид орж болохгүй” гэж, мөн Япон Улсын засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Ёошихидэ Суга Япон Улс Пхеньяны “дипломат инээмсэглэл”-д хуургаж болохгүй хэмээн ярив.³⁴

АНУ-ын дэд Ерөнхийлөгч Майк Пенс “[БНАСАУ]-д шахалтыг дээд зэргээр үзүүлэх аян үргэлжилж, улам эрчимжинэ. Тэгэхдээ яриа хэлэлцээр хийхийг хүсвэл бид яриа хэлэлцээр хийнэ” гэсэн байр суурийг илэрхийлэв.³⁵

2018 оны 02-р сарын 15-ны өдөр: ОХУ-д БНСУ-аас суугаа Элчин сайд Вү Юүн Күэн Вашингтон – Пхеньяны яриа хэлэлцээрийг эхлүүлэх боломжийн талаар илэрхийлээд “тухайлбал, АНУ-ын Конгрессын гишүүд Хойд Солонгос улстай хийх яриа хэлэлцээрийг одоо эхлүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Ийм учраас энд Хойд Солонгос улс, АНУ хооронд яриа хэлэлцээр хийгдэх боломж байгааг олж харж байна” гэж мэдээллэв.³⁶

Үүний дараахан, АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Рекс

33 “North Korean Leader Invites South Korean President to Pyongyang - Reports”, February 10, 2018, <https://sputniknews.com/asia/201802101061532722-north-korea-south-korea-visit/>

34 “Japan Won't Be Deceived by Pyongyang's 'Diplomatic Smile' – Defense Minister”, February 13, 2018, <https://sputniknews.com/asia/201802131061603853-japan-north-korea-thaw/>

35 “Disconnect between US and South Korea grows amid rapprochement with North”, February 12, 2018, <https://www.theguardian.com/world/2018/feb/12/disconnect-between-us-and-south-korea-exposed-by-seouls-new-approach-to-north>

36 “S Korean President May Visit Pyongyang If DPRK Changes Stance - S Korean Envoy”, February 15, 2018, <https://sputniknews.com/asia/201802151061706895-south-korea-us-dprk-dialogue/>

Тиллерсон “би олгогдсон боломжит хугацааг ашиглаж, анхны бөмбөг хаях хүртэл дипломат арга хэлбэрээр ажиллана. Миний ажил бол анхны бөмбөг хаях шалтгаанаас бүрэн сэргийлэх явдал. Бидэнд гэхдээ яг хэдий хэмжээний хугацаа үлдээд байгааг тодорхой хэлж мэдэхгүй байна... Үндсэн дипломатчийн хувьд миний гүйцэтгэх ажил бол манай тал харилцах сувгаа нээлттэй хэвээр хадгалж буй Хойд Солонгосын талд сайтар ойлгуулах явдал. Миний хувьд сонсоно. Миний хувьд Хойд Солонгосын талаас яриа хэлэлцээр хийхэд бэлэн гэдгээ илэрхийлэхийг нь хүлээж сонссоор байна”³⁷ хэмээн ярилцлага өгсөн. АНУ-ын Сенатын гишүүн, Сенатын гадаад харилцааны хорооны дарга Боб Коркер цөмийн хямралын асуудлыг дипломат аргаар шийдвэрлэхэд Рекс Тиллерсонд 8-10 хүртэлх сарын хугацаа олгож байгаа бөгөөд энэ хугацаанд шийдвэрлэж эс чадвал АНУ “зэвсэг хөдөлгөх хамгийн зоримог далайцтай шийдвэрийг гаргах болно” хэмээн ярьсан байна.

Энэ өдөр Япон Улсын Батлан хамгаалах яам АНУ, Япон Улсын зэвсэгт хүчний хамтарсан пуужин хамгаах цэргийн сургуулилт хийх болсныг мэдэгдсэн. Үүнийг хожим БНАСАУ “Солонгосын хойгт энх тайван тогтож, Хойд – Өмнөдийн харилцааг сайжруулах чиглэлд ихээхэн хөдөлмөр зүтгэл гарган байж олж авсан уур амьсгалыг үгүй хийх гэсэн догшин дээрэмчин лугаа үйлдэл” хэмээн төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээрээ буруушаасан.³⁸

2018 оны 02-р сарын 21-ний өдөр: АНУ-ын дэд Ерөнхийлөгч Майк Пенсийн ажлын албаны дарга Ник Аиэрс мэдэгдэл хийхдээ, Олимпийн наадмын үеэр дэд Ерөнхийлөгч БНАСАУ-ын төлөөлөгч нартай уулзах боломжтой байтал БНАСАУ-ын төлөөлөгч нар төлөвлөсөн уулзалтаас гэнэт татгалзсан гэв.³⁹

Мөн өдөр БНСУ-ын Гадаад харилцааны сайд мэдээлэл өгөхдөө, “Хоёр Солонгос хоорондын яриа ба АНУ – Хойд Солонгос хоорондын яриаг аль алийг нь үндсэн хоёр тулгуур багана гэж үзэн анхаарч ажиллахын зэрэгцээ, өргөн хүрээтэй яриа хэлэлцээр хийхийг

37 “Rex Tillerson opens up in rare, wide-ranging interview”, February 18, 2018, <https://www.cbsnews.com/news/rex-tillerson-secretary-of-state-60-minutes-interview/>

38 “N Korea Calls US-Japan Missile Drills Provocation Against Intra-Korean Dialogue”, February 22, 2018, <https://sputniknews.com/asia/201802221061911596-north-korea-us-japan-missile-drills/>

39 “North Korea canceled planned meeting with Pence”, February 21, 2018, https://www.reuters.com/article/us-northkorea-missiles/north-korea-canceled-planned-meeting-with-pence-idUSKCN1G5045?utm_source=34553&utm_medium=partner

бид шахаж ажиллах болно... Хоёр Солонгос хоорондын харилцааг сайжруулах нь Хойд Солонгосын цөмийн асуудлыг шийдвэрлэхэд хөтөлж болохыг тооцож, үүнд хүрэх бүтээлч эргэх холбоог бий болгох шаардлагатай тухай олон улсын хамтын нийгэмлэгийн зөвшилцөл, нэгдмэл ойлголтыг бид бий болгохыг эрмэлзэнэ”⁴⁰ гэв.

2018 оны 02-р сарын 23-ны өдөр: НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутеррес 2018 оны 02-р сарын 16-нд Мюнхений Аюулгүй байдлын чуулга уулзалтын нээлтийн илтгэл тавихдаа БНАСАУ-ын эсрэг авч хэрэгжүүлсэн НҮБ-ын хориг арга хэмжээг “хэвээр үргэлжлүүлэх нь асар чухал юм”⁴¹ хэмээн хэлснийг буруутгаж, БНАСАУ-ын НҮБ дахь төлөөлөгч “энэ бол НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын албан үүргийг хэрэгжүүлэгчийн хувьд зохисгүй, үндэслэлгүй хуурмаг цэцэрхэл бөгөөд [Антонио Гутеррес] нь АНУ-ыг төлөөлж буй аялдан дагалдагч төрлийн хүн биш байгаа хэмээн эргэцүүлэхэд эрхбиш хүргэлээ”⁴² гэв.

Энэ өдөр АНУ-ын Сангийн яам “Хойд Солонгос, Хятад, Сингапур, Тайвань, Хонг Конг, Маршал Арлууд, Танзани, Панама, Коморос гэсэн орнуудад байршилтай, бүртгэлтэй, эсхүл далбаа тээсэн 27 хуулийн этгээд, 28 хөлөг онгоц”, мөн Тайвань улсын паспорт эзэмшигч нэг хувь этгээдийн эсрэг хориг арга хэмжээг шинээр авч хэрэгжүүлэх болсон, цаашид ч энэ төрлийн арга хэмжээг үргэлжлүүлэн явуулах тухай мэдэгдсэн. Энэ тухай АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп “бид Хойд Солонгосын дэглэмийн эсрэг шинээр урьд байгаагүй өргөн хүрээтэй цогц хоригийг авч хэрэгжүүлж байна”, “хэрэв эдгээр хориг үр дүнд хүрэхгүй бол, бид хоёр дахь шат руу шилжих ба хоёр дахь шат бол маш хүнд хэцүү үр дагавартай буюу дэлхий ертөнцийн хувьд их харамсалтай зүйл болох талтай”⁴³ гэжээ.⁴⁴

40 “Seoul Views Inter-Korean Talks as Way to Pyongyang Denuclearization - Ministry”, February 21, 2018, <https://sputniknews.com/asia/201802211061857600-korea-talks-denuclearization-ministry/>

41 “Secretary-General’s address at the Opening Ceremony of the Munich Security Conference” <https://www.un.org/sg/en/content/sg/statement/2018-02-16/secretary-general%E2%80%99s-address-opening-ceremony-munich-security>

42 “North Korea Brands UN Secretary General a ‘Henchman’ of the United States”, February 23, 2018, <https://sputniknews.com/world/201802231061927177-un-sanctions-response-criticism/>

43 “Trump warns of ‘very rough’ ‘Phase Two’ against North Korea if sanctions don’t work: ‘Very, very unfortunate for the world’”, February 23, 2018, <http://www.businessinsider.com/trump-phase-2-north-korea-sanctions-2018-2>

44 “U.S. imposes more North Korea sanctions, Trump warns of ‘phase two’”, February 23, 2018, <https://www.reuters.com/article/us-northkorea-missiles-trump/u-s-imposes-more-north-korea-sanctions-trump-warns-of-phase-two-idUSKCN1G71RD>

Уг хоригийг Япон Улсын ерөнхий сайд Шинзо Абэгийн тусгай зөвлөх Кэнтаро Соноура⁴⁵, Баглан хамгаалахын Сайд Ицүнори Онодера нар “бүрэн дэмжиж байгаа⁴⁶”-гаа илэрхийлсэн бол, БНХАУ-ын Гадаад харилцааны яамны хэвлэлийн төлөөлөгч Генг Шуанг мэдэгдэл хийхдээ, тус хориг арга хэмжээнд БНХАУ-ын зарим хуулийн этгээд өртөөд байгаа тул АНУ-ыг “холбогдох салбарт хоёр талын хамтын ажиллагаа өрнөхөд саад учруулахаас сэргийлэх үүднээс энэ мэт алдаатай үйл ажиллагаа” явуулахаа зогсоохыг шаардсан. БНАСАУ-ын Солонгосын мэдээний төв агентлаг (KCNA) Вашингтоны зүгээс далайн хаалт тогтоох явдлыг Пхеньян дайны арга хэмжээ гэж үзэх болно⁴⁷ гэв. ОХУ-ын Холбооны улсын зөвлөлийн Олон улсын асуудал эрхэлсэн хорооны дарга Константин Косачев уг хоригийн талаар бичихдээ⁴⁸, “хориг арга хэмжээг нөхцөл байдал муудсан үед хэрэгжүүлэх бус, нөхцөл байдал намжиж хэвийн болох төлөв шинж илрэх үед авч хэрэгжүүлдэг нь Америкчуудын өвөрмөц тэнэглэл” гэв.

2018 оны 02-р сарын 25-ны өдөр: БНАСАУ-ын төлөөлөгч нар БНСУ-ын Ерөнхийлөгч Мүүн Жае Интэй уулзах үеэрээ Пхеньян Вашингтонтой яриа хэлэлцээр явуулахад бэлэн байгааг мэдэгдсэнтэй холбогдуулан⁴⁹ АНУ-ын зүгээс “Хойд Солонгостой хийх аливаа яриа хэлэлцээрийн эцсийн үр дүн нь цөмийн зэвсэггүй болох явдал байх ёстой”⁵⁰ хэмээн мэдэгдэж болзол тавив.

2016 оны 02-р сарын 26-ны өдөр: Европын Зөвлөл БНАСАУ-ын эсрэг хориг арга хэмжээгээ НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн №2397 (2017) дугаар шийдвэрийн хүрээнд чангатгав.

2018 оны 02-р сарын 27-ны өдөр: БНХАУ-ын Гадаад харилцааны яамны хэвлэлийн төлөөлөгч Солонгосын Хойгт сүүлийн

45 “U.S. slaps “heaviest” sanctions on N. Korea”, February 24, 2018, <https://english.kyodonews.net/news/2018/02/2b2048c3c8a5-update3-us-slaps-heaviest-sanctions-on-n-korea-on-56-ships-entities.html>

46 “Japan supports US’s heaviest sanctions on North Korea”, February 25, 2018, <http://vovworld.vn/en-US/news/japan-supports-uss-heaviest-sanctions-on-north-korea-622118.vov>

47 “Pyongyang Vows to Regard Any Maritime Blockade as an Act of War”, February 25, 2018, <https://sputniknews.com/asia/201802251061971104-north-korea-maritime-blockade-war/>

48 Константин Косачев, https://www.facebook.com/permalink.php?story_fbid=1631772580236831&id=100002123135703&pnref=story

49 “White House Says Yet to See if North Korea Willing to Denuclearize”, February 25, 2018, <https://sputniknews.com/asia/201802251061984932-us-north-korea-willing-denuclearize/>

50 “South Korea’s Moon urges U.S. and North to lower threshold for talks”, February 26, 2018, <https://www.japantimes.co.jp/news/2018/02/26/asia-pacific/white-house-says-will-see-north-korea-serious-talks/#.Wq-g1NRuYrl>

үед бүрэлдэж буй тогтвортой байдал бол “үүсээд буй асуудлыг яриа хэлэлцээрт үндэслэн эвийн журмаар шийдвэрлэхэд холбогдох бүх талуудыг эргүүлэн авчирч чадна” гэж үзэж буйгаа, “үүний тулд холбогдох талууд шаардлагатай арга хэмжээг авч ажиллана хэмээн найдаж байгаа” тухайгаа илэрхийлээд БНХАУ болон олон улсын хамтын нийгэмлэг бүхэлдээ Вашингтон, Пхеньян хоорондоо яриа хэлэлцээр эхлүүлэхийг хүлээж байна гэв⁵¹.

2018 оны 03-р сарын 03-ны өдөр: БНАСАУ-ын цөмийн баллистик пуужин хөгжүүлэх хөтөлбөрт АНУ-ын тагнуулын байгууллагын хийсэн үнэлгээгээр Пхеньян ахиц дэвшил гаргаж, тодорхой байнд цохилт өгөх баллистик пуужинг удирдах технологи нь сайжирсан тухай мэдээг эх сурвалжаас авсан тухай CNN агентлаг мэдээллэв⁵².

Мөн өдөр БНАСАУ-ын Гадаад харилцааны яамны хэвлэлийн төлөөлөгч Вашингтон, Пхеньян хоорондын яриа хэлэлцээрийг хийх “боломжтой” боловч ийм хэлэлцээр гагцхүү эрх тэгш байр сууринаас, ямарваа нэгэн урьдчилан тогтоосон болзол нөхцөлгүйгээр явагдах боломжтой гэж мэдээллэв. БНАСАУ-ын Солонгосын мэдээний төв агентлагийн дамжуулснаар “манай улс АНУ-тай ямар нэг урьдчилсан нөхцлийн талаар тохиролцсон үйл баримт ерөөс үгүй бөгөөд ирээдүйд ч ийм зүйл болохгүй. Бид үүсээд буй асуудлыг дипломат, энх тайванч аргаар шийдвэрлэх эрмэлзэл тээж байгаа хэдий ч яриа хэлэлцээр хийе гэж гуйхгүй, бас АНУ-ын хэлж байгаачлан цэрэг зэвсэг хөдөлгөх сонголтоос цааргалахгүй” гэж тус яамны хэвлэлийн төлөөлөгч хэлжээ.

АНУ-ын тал БНАСАУ-тай яриа хэлэлцээр хийх хүсэл эрмэлзэлтэй байгаа болохоо илэрхийлэхдээ, урьдаар цөмийн зэвсгийн хөтөлбөрөө зогсоохыг тогтмол шаардаж байсан ба Пхеньяны талд үүнийг хүлээн зөвшөөрөх боломжгүйгээ илэрхийлж “эрх тэгш байр сууринаас” яриа хэлэлцээр хийхийг шаардсан байна. АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп БНСУ-ын Ерөнхийлөгч Мүүн Жае Ин нар утсаар холбогдох үедээ “Хойд Солонгостой хийх аливаа яриа хэлэлцээр нь тус улсыг бүрэн хэмжээнд, магадлан шалгах боломжтой хэлбэрээр,

51 “China Hopes North Korea, US to Take Measures for Start of Dialogue”, February 27, 2018, <https://sptnkne.ws/gQGN>

52 “N Korea Continues to Make Progress on Missile Program - US Intelligence”, March 03, 2018, <https://sptnkne.ws/gSF5>

эргэлт буцалтгүйгээр цөмийн зэвсэггүй болгох” зорилго агуулах ёстой болохыг онцлон тэмдэглэсэн тухай Цагаан ордны хэвлэлийн төлөөлөгч өмнө мэдээллэж байжээ.⁵³

2018 оны 03-р сарын 05-ны өдөр: БНАСАУ-ын Удирдагч Ким Жон Ун БНСУ-ын үндэсний аюулгүй байдлын дарга, тагнуулын дарга зэрэг өндөр албан тушаалтнуудаас бүрдсэн төлөөлөгчдийг Пхеньянд хүлээн авч уулзав. БНАСАУ-ын Солонгосын мэдээний төв агентлагийн мэдээллэсэнээр “Хойд ба Өмнөд Солонгосын харилцааг эрчимтэй сайжруулж, дэлхий дахинд итгэл төгс байхын тулд үндэстнийхээ хувьд хүчин зүтгэлээ уялдуулан нэгтгэх замаар улс орноо эргэн нэгтгэх шинэ түүхийг бүтээх нь [Ким Жон Ун Удирдагчийн] бат хүслэн бөгөөд тууштай, зарчимчаар баримтлах байр суурь мөн гэдгийг хэдэнтээ тодотгож хэлсэн” ба уулзалт “нутаг нэгтнүүдийн элэгсэг дотно уур амьсгалд” өрнөн явагдсан байна.⁵⁴

Дээд хэмжээний уулзалтын дараа БНСУ-ын төлөөлөгч нараас мэдээлэл өгөхдөө, хоёр орны удирдагчдын хооронд телефон холболт тавигдах бөгөөд дараагийн дээд хэмжээний уулзалтын өмнө удирдагчид анх удаагаа утсаар ярихаар болсон гэв.

2018 оны 03-р сарын 06-ны өдөр: БНАСАУ-ын Удирдагчтай уулзаж ирсэн БНСУ-ын төлөөлөгч нар хоёр улс 4-р сард дээд хэмжээний уулзалт хийхээр тохирсон тухай мэдэгдэв. БНСУ-ын Ерөнхийлөгч Мүүн Жае Иний үндэсний аюулгүй байдлын зөвлөх “Өмнөд ба Хойд Солонгосын тал 4-р сарын сүүлээр Панмунжомд⁵⁵ гуравдахь удаагийн дээд хэмжээний уулзалт зохион байгуулахаар тохиролцсон” гэв. Мөн тус зөвлөхийн хэлснээр, БНАСАУ-ын эрх баригчид хоёр талын харилцааг хэвийн болгож, цөмийн зэвсэггүй болгох тухай зөвлөгөөнийг эхлүүлэх зорилгоор АНУ-тай яриа хэлэлцээр хийх хүсэлтэй байгаа тухайгаа мөн илэрхийлсэн байна.⁵⁶

53 “We Won’t ‘Beg for Dialogue’: North Korea Rules Out Talks With US Preconditions”, March 04, 2018, <https://sptnkne.ws/gSww>

54 “Pyongyang Seeks to ‘Write New History’ of Korean Unification - State Media”, March 06, 2018, <https://sptnkne.ws/gTPF>

55 Хоёр Солонгосын хилийн заагтай ойролцоо, 37.956°N 126.677°E координатад байрлах БНАСАУ-ын нутаг дэвсгэрт хамаарах тосгон. Уг тосгон нь хоёр тал уулзалт хэлэлцээр хийхэд ашиглагддаг аюулгүй байдлын хамтарсан бүсээс нэг километрийн зайтай ойр оршдог тул тус бүсийг Панмунжон тосгоны нэрээр нэрлэж заншсан.

56 “Pyongyang Agrees to Summit With Seoul, Pledges to Stop Sabre-Rattling”, March 06, 2018, <https://sptnkne.ws/gUaN>

2018 оны 03-р сарын 07-ны өдөр: АНУ-ын Төрийн департаментийн хэвлэлийн төлөөлөгч БНАСАУ-ын засгийн газар Ким Жон Намын амь насыг Куала Лумпурын нисэх буудал дээр бусниулахдаа VX химийн хорт бодисыг ашигласан гэж үзэж шинэ хориг арга хэмжээг авч буй тухай мэдэгдэв⁵⁷.

2018 оны 03-р сарын 08-ны өдөр: АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Рекс Тиллерсон “Хойд Солонгос улсад дипломат, эдийн засгийн шахалтыг бодитоор үзүүлэхийн тулд Африк тивийн улс орнууд өргөнөөр оролцохыг хүсч байна. Африкийн улс орнууд энэхүү зорилгод хувь нэмрээ оруулж чадах бөгөөд Солонгосын хойгийг цөмийн зэвсэггүй болгох олон улсын улсын үйл хэрэгт дэмжлэг туслалцаа болох үүднээс улс орон бүр арга хэмжээ авч ажиллах шаардлагатай юм” гэсэн мэдэгдэл хийв.⁵⁸

Мөн Рекс Тиллерсон, “Доналд Трамп Ерөнхийлөгчийн тэмдэглэсэнчлэн, Өмнөд Солонгос улстай хоёр Солонгосын яриа хэлэлцээр хийж байгаагаас үзэхэд Хойд Солонгос улсаас эерэг гэмээр төлөв дохиог өгч байна. Харин АНУ-тай шууд яриа хэлэлцээр хийх асуудлын хувьд бид хэлэлцээрийн түвшинд очихоос маш алс зайнд байна” гэв. Үүнтэй зэрэгцэн БНСУ-ын хэвлэл мэдээллийн хэрэгслээр БНАСАУ-ын Удирдагч Ким Жон Унаас АНУ-д хандан илгээсэн хувийн зурвасыг БНСУ-ын тусгай элч дамжуулан хүргэхээр АНУ-ын нийслэлд ирсэн тухай мэдээ гарчээ⁵⁹.

2018 оны 03-р сарын 09-ний өдөр: БНСУ-ын үндэсний аюулгүй байдлын зөвлөх Чунг Эүи Ёнг БНАСАУ-ын Удирдагч Ким Жон Ун АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамптай “аль болох эрт” уулзалдах хүсэлтэй байгаа хэмээн мэдээллэсэн гэв. Чунг зөвлөх хэлэхдээ, “Хойд Солонгос үргэлжлүүлэн цөмийн эсхүл пуужингийн туршилт явуулахаа зогсооно. Би ноён Ерөнхийлөгч Доналд Трампд Хойд Солонгосын талтай уулзах үеэр Ким Жон Ун цөмийн зэвсэггүй болох талаар чармайж

57 “State Dept Sanctions DPRK for Using Agent VX to Kill Kim Jong-un’s Half-Brother”, March 07, 2018, <https://sptnkne.ws/gUvA>

58 “US Urges African Nations to Put Diplomatic, Economic Pressure on N Korea”, March 08, 2018, <https://sptnkne.ws/hakV>

59 “N Korea Sends ‘Positive Signals’ But There Is Long Way From Talks - Tillerson”, March 08, 2018, <https://sptnkne.ws/gVkw>

ажиллахаа илэрхийлснийг уламжилсан” ба Хойд Солонгосын тал “БНАСАУ руу чиглэсэн цэрэг зэвсгийн заналхийлэл үгүй болж, Хойд Солонгосын улс төрийн дэглэмийн аюулгүй оршин тогтнолд баталгаа олгогдсон цагт цөмийн зэвсэг эзэмших хэрэгцээ шаардлага байхгүй” тухайгаа илэрхийлсэн гэв. Доналд Трамп Ерөнхийлөгч Кимийн уулзах хүсэлтийг хүлээн авч түүнтэй 5-р сард уулзах сонирхолтой байгаагаа илтгэжээ.⁶⁰ Цагаан ордны хэвлэлийн нарийн бичгийн дарга Сара Хукаби Сандэрс мэдэгдэхдээ, “[Доналд Трамп Ерөнхийлөгч] Ким Жон Унтай уулзалт хийх урилгыг хүлээн авах бөгөөд уулзалт болох газар, цагийг ирээдүйд тодорхойлно” гэсэн ба АНУ-ын Ерөнхийлөгч өөрийн твиттер хуудсанд “...уулзалт төлөвлөгдөж байна!” хэмээн бичив, Энэ мэдээг Япон Улсын Ерөнхий сайд Шинзо Абэ талархан хүлээн авч байгаагаа илтгэв. ОХУ-ын Гадаад хэргийн сайд Сергей Лавров “Ийм тохиролцоо яригдсан талаар бид өнөөдөр олж сонслоо. Энэ нь ажил хэрэг болно хэмээн найдаж байна. Энэ бол Солонгосын хойгт үүсээд буй нөхцөл байдлыг намжааж хэвийн болгоход шаардагдаж байсан алхам. Энэ алхам зөвхөн яриа хэлэлцээр төдий болж дуусалгүй, зургаан талт хэлэлцээр болон НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн хүрээнд ярьж зөвшилцсөн тэдгээр зарчмуудыг баримтлан Солонгосын хойг дахь цөмийн асуудлыг эвийн журмаар шийдвэрлэхэд чиглэсэн өргөн хүрээтэй улс төрийн яриа хэлэлцээрийн суурийг тавих ёстой” гэв.

60 “Trump Agrees to Meet Kim Jong-un, Who is Now 'Committed' to Denuclearization”, March 09, 2018, <https://sptnkne.ws/gVsM>